

## **ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ЖУРАМ**

### **Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Монгол Улсын Боловсролын болон Дээд боловсролын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, журмыг баримтлан Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль (цаашид ХИС гэх)-д дээд боловсролын зэрэг олгох сургалт зохион байгуулахад энэ журмыг мөрдөнө.
- 1.2. Бакалаврын боловсролын зорилго нь бүрэн дунд боловсролтой иргэнд сургалт, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт мэргэжлийн түвшинд ажиллахад шаардагдах тодорхой шинжлэх ухааны суурь мэдлэг эзэмшүүлж, цаашид өөрийгөө хөгжүүлэх онол-арга зүйн мэдлэг, чадвар, соёлыг төлөвшүүлэхэд оршино.
- 1.3. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал ХИС-ийн Захиргааны зөвлөл хэлэлцэж, захирал шийдвэр гаргана.

### **Хоёр. ЖУРМЫН НЭР ТОМЪЁО**

- 2.1. Дээд боловсролын зэрэг нь багц цагаар хэмжигдэх бакалаврын, магистрын, докторын шатлалтай байна.
- 2.2. Бакалаврын зэрэг нь дээд боловсролын анхан шатны зэрэг бөгөөд суралцагчийг оюутан гэнэ.
- 2.3. Багц цаг (Credit) нь боловсролын агуулгын багтаамжийг жиших нэгж бөгөөд оюутны суралцах ачаалал, багшийн сургалтын ажлын хэмжээ, сургалтын төлбөрийг тогтоох үндсэн хэмжүүр, дээд боловсролын зэрэг олгох сургалтад тавигдах стандартын шаардлага, сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, зохион байгуулалтын харилцааг зохицуулах үндэслэл болно. Нэг багц цагийн хэмжээ нь 15 долоо хоногтой улирлын хувьд 30 цагтай тэнцүү байна.
- 2.4. Хичээлийн багц цаг нь хичээлийн агуулгыг илэрхийлэх бүхэл тоо байх бөгөөд хэмжээ нь долоо хоногт тухайн хичээлийг судлах цаг, хэлбэрээс хамаарна. Оюутны нэг долоо хоногт сурах үйл ажиллагаанд зарцуулах дараах багц бүрийг нэг багц цаг гэж тодорхойлно. Үүнд:
  - 2.4.1. Лекцийн 1 цаг + оюутны бие даан суралцах 2 цаг;
  - 2.4.2. Семинарын 2 цаг + оюутны бие даан суралцах 1 цаг;
  - 2.4.3. Лабораторийн хичээлийн 3 цаг;
- 2.5. Тодорхой түвшний боловсрол эзэмшүүлэхэд чиглэсэн сурах, сургах үйл ажиллагааны агуулга, зохион байгуулалтыг тодорхойлсон цогц баримт бичгийг хөтөлбөр гэнэ.
- 2.6. Сургалтын төлөвлөгөө нь дээд боловсролын сургалтын зохион байгуулалт, агуулгын багтаамж, судлах хичээлийн жагсаалт, тэдгээрийн багц цагаар илэрхийлсэн багтаамж, дараалал, тодорхойлолт, дадлагын төрлийг тусгасан баримт бичиг мөн.

- 2.7. Хичээлийн хөтөлбөр нь сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл бүрээр оюутны эзэмшвэл зохих онол, практикийн мэдлэг, чадвар, дадал, хандлагын агуулга, үнэлгээ, тухайн хичээлийн багтаамж, ашиглавал зохих ном, сурах бичгийн жагсаалтыг заасан баримт бичиг юм.
- 2.8. Хичээлийн индекс. ХИС-д заах бүх хичээл нэгдсэн индекстэй байна. Индекс нь уг шинжлэх ухааны салбарын ерөнхий нэрийн эхний 3 үсэг (англиар) ба 3 оронтой тооноос тогтоно. 3 оронтой тооны эхний орон уг хичээлийн төвшнийг, дараагийн хоёр орон тухайн хичээлийн дугаар (хичээл хоорондын уялдаа холбоо, эрэмбэ дарааллыг харгалзан тогтооно)-ыг заана.
- 2.8.1. Заавал үзэх (Compulsory) хичээл. Тухайн хөтөлбөрийн хувьд зайлшгүй судлах шаардлагатай хичээл юм.
- 2.8.2. Сонгон судлах (Elective) хичээл. Тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний бүлэг бүрээр авбал зохих багц цагийг гүйцээх зорилгоор тодорхой багц цаг бүхий хичээлийг оюутан сонгон судлах хичээл юм.
- 2.8.3. Өмнөх холбоот (Prerequisite) хичээл. Тодорхой хичээлийг судлахаас өмнө амжилттай судалсан байвал зохих хичээл.
- 2.8.4. Давхар холбоот (Corequisite) хичээл. Тухайн хичээлтэй зэрэгцүүлэн судлах хичээл.
- 2.8.5. Ерөнхий суурь (General Education) хичээл. Оюутанд дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндэс буюу ойлгомжтой ярих, бичих; тоон болон тоон бус мэдээллийг боловсруулах; олон ургальч үзэл баримтлалын учир шалтгааныг таньж мэдэх; бусад мэргэжлийн хүмүүстэй үр дүнтэй хамтарч ажиллах, харилцан суралцах мэдлэг, чадварыг заавал болон сонгон суралцах хэлбэрээр эзэмшүүлэх зорилготой хичээл.
- 2.8.6. Мэргэжлийн суурь (Core) хичээл. Оюутанд суралцах үндсэн чиглэлийнх нь шинжлэх ухааны суурь мэдлэгийг олгох, тухайн талбарт асуудал шийдвэрлэх, бүтээлчээр сэтгэх мэдлэг, чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой заавал судлах хичээл юм.
- 2.8.7. Мэргэжлийн (Major) хичээл. Оюутны суралцах үндсэн чиглэл буюу тухайн шинжлэх ухааны тодорхой мэдлэг, чадвар, дадлыг заавал болон сонгон суралцах хэлбэрээр эзэмшүүлэх зорилготой бүлэг хичээл.
- 2.8.8. Хавсарга мэргэжлийн (Minor) хичээл. Тодорхой болзол хангасан оюутан суралцаж байгаа үндсэн чиглэлийнхээ мэргэшүүлэх хичээлээс цуглуулах багц цагийг заасан хэмжээгээр багасган, тухайн чиглэлд хоёр дахь мэргэшлийг эзэмших, эсвэл суралцаж байгаа чиглэлээсээ өөр чиглэлээр давхар мэргэших тохиолдолд заавал болон сонгон судлах хэлбэрээр үзвэл зохих бүлэг хичээл юм.
- 2.9. Голч дүн. Оюутны эзэмшсэн мэдлэг, чадварын тоон болон чанарын үнэлгээний нэгдэл бөгөөд голч онооны адил аргачлалаар бодно.
- 2.10. Дадлагын хичээл. Оюутны танхимийн сургалтаар эзэмшсэн онолын мэдлэг, чадварыг практик үйл ажиллагаатай холбон, бататган гүнзгийрүүлэх зорилгоор үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, хээрийн нөхцөлд тусгайлан зохион байгуулах сургалтын хэлбэр.
- 2.11. Бакалаврын судалгааны ажил. Бакалаврын сургалтын агуулгыг дүүргэж буй оюутан тухайн үндсэн мэргэшлээр бакалаврын зэргийн дээд боловсрол эзэмшихэд зайлшгүй шаардагдах

мэдлэг, чадвар, дадлыг эзэмшсэнээ баталгаажуулах, судалгаа шинжилгээний ажлын суурь мэдлэг, чадвар эзэмших зорилгоор хийж болох судалгааны ажил юм.

### **Гурав. КРЕДИТ СОНГОН СУРАЛЦАХ СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 3.1. Бакалаврын зэрэг олгох сургалтын ажлыг сургалт, судалгааны хөгжил, аудитын үйлчилгээний алба (цаашид ССХАҮА гэх) удирдлагаар хангаж, зохион байгуулна.
- 3.2. Оюутан тухайн улиралд судлах хичээлүүдээ сонгон суралцах эрхтэй.
- 3.3. Хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн агуулга, стандартыг мэргэжлийн тэнхимийг түшиглэн боловсруулж, баталгаажуулах болон хэрэгжүүлэх ажлыг ССХАҮА зохион байгуулна.
- 3.4. Оюутны кредит сонголт буюу хичээл сонголтыг 2 үе шаттайгаар явуулна. 1-р үе шат нь урьдчилсан захиалга буюу СОНГОЛТ-1, 2-р үе шат нь эцсийн бүртгэл буюу СОНГОЛТ-2 байна.
- 3.5. Оюутан СОНГОЛТ-1-д дараагийн улиралд суралцахаар төлөвлөсөн хичээл тус бүрийг сонгон, захиалгаа ССХАҮА-д цаасан эсвэл цахим хэлбэрээр сургалтын нэгдсэн хуанлид заасан хугацаанд багтаан өгч баталгаажуулна.
- 3.6. Оюутан хичээл сонгохдоо сургалтын төлөвлөгөөнд заасан хичээлүүдийн өмнөх болон давхар холбоог сайтар анхааран, өмнөх холбоо бүхий хичээлүүдийг дарааллын дагуу сонгоно.
- 3.7. ССХАҮА-аас оюутны СОНГОЛТ-1-ийг үндэслэн, тухайн улиралд заах хичээлийн жагсаалт, тэдгээрийг заах багш, анги танхимын хуваарилалтыг үзүүлсэн “Хичээлийн ерөнхий хуваарь” гаргана.
- 3.8. Хичээлийн ерөнхий хуваарь гарсны дараа оюутнууд тухайн улиралд судлах хичээлээ ямар багшаар заалгах, ямар хуваариар хичээллэхээ сонгон, СОНГОЛТ-2-г хийнэ.
- 3.9. Дан мэргэжлийн ангийн оюутнуудын хувьд нэг хичээлийн жилд судлах кредитийн доод хэмжээ 20, дээд хэмжээ нь 46 байна. Хос мэргэжлийн ангийн оюутнуудын хувьд сонгон судлах кредитийн доод хэмжээ 38, дээд хэмжээ нь 51 байна.
- 3.10. Оюутан СОНГОЛТ-1 хийсний дараа СОНГОЛТ-2 хийх хугацаанд сонголтдоо өөрчилж болно. Сонголт өөрчилсөн тухайгаа ССХАҮА-д цаасан болон цахим хэлбэрээр мэдэгдэнэ.
- 3.11. Оюутнаас үл хамааран мэргэжлийн тэнхимийн багш нарын хүрэлцээ, анги танхимын хүрэлцээ, групп бүрдэлт зэргээс хамааран СОНГОЛТ-1-д өөрчлөлт орж болно. Нэг группт хичээллэх оюутны тоо лекцийн ангид 150 хүртэл, хэлний семинарын бүлэгт 25, лабораторийн ангиудын нөхцөлөөс шалтгаалан 15-20, бусад семинарын бүлэгт 30 оюутнаар хязгаарлагдана. Энэхүү өөрчлөлтийг ССХАҮА хийх бөгөөд сонголт өөрчлөгдсөн тухай мэдээллийг оюутнуудад цахим хэлбэрээр хүргэнэ.
- 3.12. Зайн сургалтанд хамрагдаж буй оюутнуудын хувьд зөвлөх багштайгаа холбогдон дараагийн улиралд судлах хичээлийн СОНГОЛТ-1-ыг вебээр онлайн хэлбэрээр хийн тухайн улирлын 13 дахь долоо хоногт багтаан зөвлөх багшдаа мэдэгдэнэ.
- 3.13. Зайн сургалтанд хамрагдан суралцаж буй оюутанд хичээл зааж буй багшийн ачаалал, төлбөрийн нөхцөл зэргийг зайн сургалтын журам болон гэрээгээр зохицуулна.
- 3.14. Сургалтын нэгдсэн хуанлид заасан хугацаанд хичээл сонголт 1,2 хаагдана.
- 3.15. Онцлох шалтгаанаар заасан хугацаанд хичээл сонголтдоо хийж, бүртгүүлж амжаагүй оюутан тухайн улирлын эхний 4 долоо хоногт багтаан бүртгүүлэх боломжтой хичээлд бүртгүүлнэ.

Бусад тохиолдолд бүртгэлийн хураамж төлж, улирлын эхний 7 долоо хоногийн дотор хичээлээ сонгож, бүртгүүлж болно. Бүртгэлийн хураамжийг Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн тогтооно.

- 3.16. СОНГОЛТ-1 хийсний дараа сонгосон кредитийн төлбөрийг төлж, СОНГОЛТ-2-оор оюутны хичээл сонголт баталгаажна. Төлбөрийн талаарх мэдээлэл болон хичээл баталгаажсан эсэх талаарх мэдээллийг удирдлагын мэдээллийн системээс авах боломжтой.
- 3.17. Хэрэв оюутан тухайн улиралд хичээл сонголт хийхгүй, СОНГОЛТ-2 хийгдээгүй бол эцэг, эх, санхүүжүүлэгч талд мэргэжлийн тэнхим мэдэгдэнэ.
- 3.18. Улирлын эхний 2 долоо хоногийн хугацаанд баталгаажаагүй бүртгэлүүдийг ССХАҮА цуцална.
- 3.19. Суралцах хугацаандаа 90–ээс доошгүй кредит цуглуулсан, 3.5-аас дээш голч дүнтэй оюутан өөрөө хүсвэл үндсэн ачааллаас нэмэлтээр магистрантурын хичээлүүдээс сонгон суралцаж болно.
- 3.20. Оюутан тухайн улиралд судалсан хичээлд хангалтгүй үнэлгээ авсан буюу 60–аас доош үнэлэгдсэн бол сургалтын төлөвлөгөөнд заагдсан улиралд уг хичээлийг дахин судлах хүсэлт гарган, урьдчилсан захиалга өгнө.
- 3.21. ССХАҮА хичээл сонголт-1-ын дагуу групп бүрдэх эсэхийг хянан, групп бүрдээгүй нөхцөлд хүлээлгийн жагсаалтанд оюутныг бүртгэн, хичээлийг судлах боломжтой болсон үед оюутанд цахим шуудангаар мэдэгдэнэ.
- 3.22. Оюутан хангалтгүй үнэлэгдсэн хичээлийг дахин судлахдаа 1 улиралд үндсэн ачаалал дээр нэмж 8 багц цаг хичээлийг сонгон судалж болно.
- 3.23. Оюутан өмнөх холбоо бүхий хичээлийн эхний хичээлд хангалтгүй үнэлэгдсэн бол, тухайн хичээлийг дахин судалсны дараа дараагийн хичээлийг судална.
- 3.24. Хичээл дахин судлах оюутан журмын 3.16–д заасны дагуу багц цагийн төлбөрийг төлж, сонголтоо баталгаажуулна.

### **Дөрөв. ХӨТӨЛБӨР, СУРАЛЦАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

- 4.1. Мэргэжлийн стандарт, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох дүрэм журамд нийцүүлэн мэргэжлийн тэнхимүүд хөтөлбөрөө боловсруулна.
- 4.2. Хөтөлбөрийн загварыг хөтөлбөрийн хороо боловсруулан мэргэжлийн тэнхимүүдэд хүргүүлэхээс гадна хөтөлбөрийн боловсруулалтыг удирдлагаар хангаж ажиллана.
- 4.3. Хөтөлбөрүүдийг Эрдмийн зөвлөл хэлэлцэж, захирал батална.
- 4.4. Хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, ажил олгогчдын хэрэгцээ шаардлага, боловсролын орчинд гарч буй өөрчлөлт зэргээс шалтгаалан шаардлагатай нөхцөлд хөтөлбөрт өөрчлөлт оруулах саналыг мэргэжлийн тэнхим гаргана.
- 4.5. Мэргэжлийн тэнхим хөтөлбөрт өөрчлөлт оруулах саналаа хөтөлбөрийн хороонд гаргана. Саналыг хөтөлбөрийн хороо хэлэлцэн дүгнэлт гаргана.
- 4.6. Бакалаврын зэрэг олгох сургалтын төлөвлөгөө нь 120 багц цагаар хэмжигдэх агуулга бүхий онолын болон дадлагын хичээлүүдээс тогтоно.
- 4.7. Сургалтын төлөвлөгөө нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн (үндсэн, хавсарга) болон сонгон судлах хичээлийн бүлгээс бүрдэж болно. Оюутанд тухайн шинжлэх ухааны чиглэлээр өргөн хүрээтэй, ерөнхий мэдлэг, чадвар эзэмшүүлэх; тэр

дагуу хоёр дахь мэргэшлийг эзэмшүүлэх; эсвэл суралцаж байгаа чиглэлээсээ өөр чиглэлээр давхар мэргэших боломж олгох зэрэг хөтөлбөрийн зорилгоос хамааруулан сургалтын төлөвлөгөөний бүтцийг уян хатан тогтооно.

- 4.8. Оюутан хавсарга мэргэжлээр, эсвэл суралцаж байгаа чиглэлээсээ өөр давхар мэргэжлээр суралцах тохиолдолд хөтөлбөрийг санал болгож байгаа мэргэжлийн тэнхим өмнөх болон давхар судалвал зохих хичээл, суралцсан хугацааны голч дүнгийн босго зэрэг холбогдох дүрэм, журамд нийцсэн тусгай шаардлагуудыг сургалтын төлөвлөгөөнд тодорхой тусгана.
- 4.9. Ерөнхий суурь: нийт багц цагийн 30 хувиас хэтрэхгүй байна. (үүний дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тодорхойлсон нийтээр заавал судлах хичээл нийт 12 багц цагаас хэтрэхгүй байна.) Заавал болон сонгон судлах хичээлүүдээс бүрдэнэ. Энэ бүлэг дэх хичээл тухайн мэргэжлийн чиглэлд багтаж буй бол оронд нь оюутны судлах, дүйцэхүйц бусад хичээлийг оруулна.
- 4.10. Мэргэжлийн суурь: нийт багц цагийн 25 хувиас хэтрэхгүй байна. (энэ бүлэг хичээлийн агуулгыг холбогдох хөтөлбөрийн магадлан итгэмжлэх байгууллагын тодорхойлсон хүрээнд бүрдүүлнэ.) Авбал зохих багц цагийн 30-аас доошгүй хувийг амжилттай цуглуулсан оюутан мэргэших үндсэн чиглэлээ тодорхойлж, тухайн мэргэжлийн хөтөлбөр харьяалагдах тэнхим, салбар сургалтын албанд хандан сонголтоо баталгаажуулна.
- 4.11. Мэргэжлийн: нийт багц цагийн 45 хувиас доошгүй байна. Хичээл нь заавал болон сонгон судлах хэлбэртэй байх бөгөөд оюутанд дан мэргэшил эзэмшүүлэх бол нийт багц цаг нь 36, бусад тохиолдолд 18-24 байна.
- 4.12. Бакалаврын судалгааны ажил нь 4 багц цагийн багтаамжтай байх ба үндсэн мэргэжлийн сургалтын төлөвлөгөөний мэргэжлийн бүлгийн заавал судлах хэсэгт тусгана. Бакалаврын судалгааны ажлын шаардлага, зохион байгуулалтыг тусад нь журмаар зохицуулна.
- 4.13. Оюутан суралцаж байгаа үндсэн чиглэлийнхээ мэргэжлийн хичээлээс цуглуулах багц цагийг 18 болгож багасган, тухайн чиглэлд хоёр дахь мэргэжлийг эзэмших, эсвэл суралцаж байгаа чиглэлээсээ өөр чиглэлд хавсарга хэлбэрээр суралцаж болно. Үндсэн чиглэлийнхээ мэргэжлийн хичээлээс цуглуулах багц цагийн 60-аас доошгүй хувийг амжилттай цуглуулсан, хавсарга хөтөлбөрийг хариуцсан мэргэжлийн тэнхим/профессорын багаас тавьсан тусгай шаардлагуудыг хангасан оюутан тухайн хавсарга хөтөлбөр харьяалагдах мэргэжлийн тэнхим/профессорын баг, салбар сургалтын албанд хандан хүсэлтээ баталгаажуулна.
- 4.14. Дан чиглэлээр болон ижил чиглэлд хавсарга мэргэжил эзэмшиж буй оюутан ерөнхий суурь болон мэргэшүүлэх бүлгийн сонгон судлах хичээлээс гадна чөлөөт хэлбэрээр 6 багц цагаас доошгүй агуулгын багтаамжтай хичээлийг сонгож үзнэ.
- 4.15. Оюутан эзэмшихээр суралцаж буй үндсэн мэргэжлийнхээ сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлийг бүрэн судалж, мэргэшүүлэх хичээлийн багц цагийн 1/3-ийг амжилттай цуглуулсан, суралцсан хугацааны голч дүн 3.2-оос дээш байх нийтлэг шаардлагыг хангахаас гадна 4.8-д заасанчлан мэргэжлийн тэнхимийн тавьсан бусад тусгай шаардлагыг хангасан тохиолдолд хос мэргэжлээр суралцах хүсэлт гаргаж болно.
- 4.16. Оюутны бакалаврын зэргээр суралцах ердийн хугацаа 4 жил, дээд хугацаа ердийн хугацаанаас 2 хүртэл жилээр илүү байх ба тодорхой нөхцөлд үүнээс өөр байж болно.

(Суралцах хэлбэр: Өдөр)

	Элсэгчдийн боловсрол	Суралцах хэлбэр	Авбалзох ихдөөд ба гццаг	Суралцах дундаж жил	Эзэмшихээрэг
А	Бүрэндунд	<u>Дан үндсэн чиглэлээр мэргэших</u> <ul style="list-style-type: none"><li>· Ерөнхий суурь хичээл (заавал болон сонгон судлах)</li><li>· Мэргэжлийн суурь хичээл (заавал болон сонгон судлах)</li><li>· Мэргэжлийн хичээл (заавал болон сонгон судлах)</li><li>· Сонгонсудлах хичээл</li></ul>	120 24-30 24-30 45-47 15	4	Бакалавр
Б	Бүрэндунд	<u>Ижил чиглэлд хавсарга мэргэшил эзэмших</u> <p>Ерөнхий суурь хичээл (заавал болон сонгон судлах)</p> <p>Мэргэжлийн суурь хичээл (заавал болон сонгон судлах)</p> <p>Үндсэн мэргэжлийн хичээл (заавал болон сонгон судлах)</p> <p>Хавсарга мэргэжлийн хичээл (заавал болон сонгон судлах)</p>	120 24-30 24-30 30-42 15*	4	Бакалавр

Бүрэндунд	<u>Өөр чиглэлд хавсарга мэргэшил эзэмших</u>	120	4	Бакалавр
	Ерөнхий суурь хичээл (заавал болон сонгон судлах)	24-30		
	Мэргэжлийн суурь хичээл (заавал болон сонгон судлах)	24-30		
	Үндсэн мэргэжлийн хичээл (заавал болон сонгон судлах)	30-42		
	Хавсаргамэргэжлийнх ичээл (заавалболонсонгонсу длах)	15*		

\*- Мэргэжлийн тэнхимүүд санал болгох

### Тав. ЗӨВЛӨХ БАГШ

- 5.1. Зөвлөх багшийг тухайн хөтөлбөрийг хариуцсан координатор багш гүйцэтгэнэ.
- 5.2. Зөвлөх багшийг мэргэжлийн тэнхимийн саналыг үндэслэн ХИС–ийн захирлын тушаалаар томилно.
- 5.3. Зөвлөх багш нь дараах үүргийг гүйцэтгэнэ.
  - 5.3.1. Сургалтын төлөвлөгөөнд тусгасан дээд боловсролын агуулгыг хэрхэн эзэмших, эзэмшсэн мэдлэг, чадвар, дадалд ямар ямар шаардлага тавьдаг болохыг оюутанд ойлгуулна.
  - 5.3.2. Оюутанд улирал бүрийн хичээл сонголтыг оновчтой зөв хийхэд нь зөвлөж, хянана. Оюутан бүрийг хэвийн ачаалалтай, сургалтаа зөв төлөвлөхөөр хичээл сонголтыг хийлгэнэ. Түүнчлэн хичээлүүдийн өмнөх болон давхар холбоог сайтар таниулна.
  - 5.3.3. Оюутанд хичээлийн хуваариа хийхэд нь зөвлөж тусална.
  - 5.3.4. Оюутан улиралд сонгосон хичээлийн кредитийн ачааллыг дараах байдлаар ангилна. Үүнд:
    - бага 12-13 кредит,
    - хэвийн 14-17 кредит,
    - их 18-23 кредит
  - 5.3.5. Оюутны хувийн мэдээлэлд гарсан өөрчлөлтөөс сургуулийн удирдлагын мэдээллийн санд оруулах шаардлагатай мэдээг улирал бүрийн эхэнд сургалтын алба, холбогдох нэгжид уламжлан өөрчилнө.

5.3.6.Оюутанд сургалтын нэгдсэн хуанли, холбогдох дүрэм журмуудтай танилцаж мөрдөх, хичээл сонголт, оюутны хичээлийн хуваарийг хийхэд зааварчлан туслах үүрэгтэй.

5.3.7.Оюутан суралцах хугацааныхаа туршид зөвлөх багшаас зөвлөгөө авч, хамтран асуудлыг шийдвэрлэнэ.

## **Зургаа. ГАДААД, ДОТООДЫН ИХ ДЭЭД СУРГУУЛИАС ОЮУТАН ШИЛЖИН СУРАЛЦАХ**

- 6.1. Дараах нөхцөлийг хангасан оюутан ХИС-д шилжин суралцах хүсэлт гаргаж болно.
  - 6.1.1.Дээд боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр байгууллага, хөтөлбөр нь магадлан итгэмжлэгдсэн, аттестатчилагдсан дотоодын их, дээд сургуульд суралцаж байсан оюутан байх
  - 6.1.2.ХИС–тай хамтын ажиллагаатай болон оюутан солилцох, кредит хүлээн зөвшөөрөх гэрээ байгуулсан гадаад, дотоодын их дээд сургуульд суралцаж байсан оюутан байх
  - 6.1.3.5.1.1, 5.1.2–т заасан их дээд сургуулиудад 1–ээс доошгүй жил суралцсан, суралцах хугацаандаа жилд 24–өөс доошгүй багц цаг цуглуулсан байх
  - 6.1.4.Голч дүн 1.7-оос багагүй байх
  - 6.1.5.ХИС–д шилжин суралцах үндэслэл шалтгаан тодорхой байх.
- 6.2. Оюутны өмнөх сургуульд судалсан хичээлийн багц цагийг шилжүүлэн тооцох асуудлыг тухайн салбар сургуулийн ССХАҮА-ны менежер, мэргэжлийн тэнхимийн эрхлэгчтэй хамтран шийднэ.
- 6.3. 5.1-т заасан нөхцөлийг хангасан оюутан шилжин суралцах хүсэлт гаргасан нөхцөлд багц цагийн зөрүүг тооцсоны үндсэн дээр мэргэжлийн тэнхим түвшин тогтоох шалгалт авч, дүнг салбар сургуулийн сургалтын менежерт өгнө. Шалгалтын дүнг харгалзан оюутныг шилжүүлэн суралцуулах боломжтой эсэхийг мэргэжлийн тэнхимийн эрхлэгч тодорхойлон, ХИС–ийн захирлын тушаалаар баталгаажна.
- 6.4. Оюутны өмнө судалсан дээд боловсролын суурь хичээлүүд болон мэргэжлийн суурь хичээлүүдээс 75–аас хэтрэхгүй багц цагийг шилжүүлэн тооцно.
- 6.5. Тухайн оюутан өмнө нь судалсан кредитээ стандарт агуулгаар нь таарч байгаа тохиолдолд дүйцүүлэн кредитийг тооцуулж болно.
- 6.6. Оюутны судалсан хичээл нь сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээлийн стандартад нийцээгүй тохиолдолд багц цагийг шилжүүлэн тооцохгүй.
- 6.7. Шилжин суралцах эрх нь баталгаажсан оюутан зөвлөх багштай хамтран үлдсэн багц цагийг ямар хугацаанд судлахаа шийдэн, хичээл сонголтоо хийж, төлбөрийг бүрэн төлсөнөөр сонголт баталгаажна.
- 6.8. Шилжин суралцах тухай хүсэлтийг улирлын эхний долоо хоног дуусах хүртэл хугацаанд хүлээн авч, салбар сургуулийн ССХАҮА-ны менежер болон мэргэжлийн тэнхим долоо хоногийн дотор хариуг оюутанд мэдэгдэнэ.
- 6.9. Шилжин суралцах хүсэлт гаргах оюутан дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:
  - Шилжин суралцах шалтгаанаа тодорхой бичсэн өргөдөл
  - Өмнө суралцаж байсан сургуулийн суралцаж байсан нь үнэн болохыг гэрчлэх албан ёсны тодорхойлолт
  - Иргэний үнэмлэхийн хуулбар



- ЕБ-ийн бүрэн дунд боловсролын гэрчилгээ, хуулбарын хамт
- 2 хувь зураг
- Анх элсэн орсон сургуулийн томиллолт
- Анх элссэн сургуулийн элссэн болон сургуулиас гарсан тухай захирлын тушаалын хуулбар
- Тухайн сургуулийн сургалтын албаны тамга, тэмдэг, албан тушаалтны гарын үсэг бүхий албан бланк дээр хэвлэсэн дүнгийн тодорхойлолт /Хэрэв гадаадын их, дээд сургуулиас шилжин ирж буй бол дүнгийн хуудас болон тодорхойлолтыг орчуулсан байх/
- Тухайн сургуульд элсэхдээ өгсөн элсэлтийн ерөнхий шалгалтын батламж
- Түвшин тогтоох шалгалтын хураамж

### **Долоо. ХИС-ИЙН ХӨТӨЛБӨР ХООРОНД ОЮУТАН ШИЛЖИН СУРАЛЦАХ**

- 7.1. Дараах нөхцөлийг хангасан ХИС-ийн оюутан өөр хөтөлбөрт шилжин суралцах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:
  - 7.1.1.ХИС-д элсэх болзол хангаж элсэн, 2-оос доошгүй улирал 3.4 болон түүнээс дээш голч дүнтэй суралцсан байх
  - 7.1.2.Мэргэжлийн хөтөлбөр хоорондын элсэлтийн шалгалтын зөрөөгүй байх
  - 7.1.3.Суралцаж байгаа хөтөлбөртөө хөнгөлөлттэй нөхцөлөөр, эсвэл аль нэг байгууллагын гэрээний дагуу элсээгүй байх
- 7.2. Оюутан хөтөлбөр хооронд шилжих хүсэлтээ өөрийн суралцаж буй бүрэлдэхүүн сургуулийн захиралд илэрхийлнэ. Хөтөлбөр хооронд шилжих хүсэлтийг улирал эхлэхээс 14 хоногийн өмнө хүлээн авч шийдвэрлэнэ.
- 7.3. Оюутны шилжин суралцах хүсэлтэй хөтөлбөрийн хувьд оюутны тоо, багш нарын хүрэлцээ зэргээс хамааран хүсэлтийг хүлээн авах боломжгүй нөхцөлд улирал эхлэхээс долоо хоногийн өмнө оюутанд мэдэгдэнэ.
- 7.4. Хөтөлбөр хооронд оюутан 1 удаа шилжих боломжтой.

### **Найм. СУРГАЛТЫН ТӨЛБӨР**

- 8.1. Сургалтын нэг багц цагийн үнэлгээг ХИС-ийн дүрэмд заасны дагуу Удирдах зөвлөлийн хурлаар тогтоон нийтэд мэдэгдэнэ.
- 8.2. Оюутан тухайн улиралд сонгосон хичээлийн багц цагийг тухайн мэргэжлийн нэг багц цагийн үнэлгээгээр үржсэн нийлбэр дүнг оюутны вебээр СОНГОЛТ-2-ийг хийж, санхүү болон ССХАҮА-д банкны хуулбараар баталгаажуулж, хичээл сонголт дуусгавар болно.
- 8.3. Сургалтын төлбөрөө хийж сонголтдоо идэвхжүүлээгүй оюутнуудын сургалтын гэрээг захиргааны санаачилгаар цуцлан захирлын тушаал гаргана.
- 8.4. 4-6 улирал дараалан амжилттай суралцан эрдэм шинжилгээний ажил болон нийгэмд хандсан боловсролоор үйлчлэх ажилд идэвх зүтгэлтэй оролцож байгаа оюутны сургалтын төлбөр хөнгөлөх, урамшуулах арга хэмжээг авна.
- 8.5. Сургалтын төлбөртэй холбогдох асуудлыг оюутны бичгээр гаргасан өргөдлийг харгалзан захирлын тушаалаар шийдвэрлэнэ. Сургуулийн захиргаанд (ССХАҮА-д) өргөдлөө бичгээр өгөөгүй байсан бол сургалтаас чөлөөлөх өдрийг бичгээр өргөдөл өгсөн өдрөөр тасалбар

- болгон сургалтын төлбөрийн тооцоог хийнэ. Өргөдөл өгсөн өдөр хүртэл хугацааг суралцсанаар тооцно.
- 8.6. Эрүүл мэндийн шалтгаанаар сургуулиас чөлөөлөгдөх нөхцөлд эмч нарын зөвлөлгөөний магадлагааг харгалзан тушаал гарсан өдрөөс хойших хугацааны сургалтын төлбөрийг бүрэн хэмжээгээр буцаан олгоно.
  - 8.7. Хичээлийн жилд онцлох шалтгаанаар хичээлд суулгүйгээр сургуулиас гарч буй оюутанд энэ тухай захирлын тушаал гарсан өдрөөс хойших хугацааны сургалтын төлбөрийн 90 хувийг буцаан олгоно.
  - 8.8. Өөрийн хүсэлтээр буюу бусад шалтгаанаар сургуулиас гарсан тохиолдолд суралцаагүй хугацааны сургалтын төлбөрийн 75 хувийг буцаан олгоно.
  - 8.9. Тухайн улиралд судалбал зохих нийт кредитийн 75-аас дээш хувьд сул дүн үзүүлж сурлагаар хасагдсан, шалтгаангүйгээр болон сураггүй алга болсон тохиолдолд оюутны сургалтын төлбөрийг буцааж олгохгүй.

### **Ес. ТӨГСӨЛТ**

- 9.1. Суралцах хугацаандаа дан мэргэжлийн хувьд мэргэжлийн стандартын шаардлагад заасан 90–ээс багагүй багц цагийг цуглуулсан, хос мэргэжлийн хувьд 135–аас багагүй багц цагийг цуглуулсан оюутныг төгсөх оюутан гэж үзнэ.
- 9.2. Бакалаврын сургалтын төлөвлөгөөн дэх дээд боловсролын суурь хичээлүүд, мэргэжлийн суурь хичээлүүд, мэргэжлийн хичээлүүдийг бүрэн судалж, 120-оос доошгүй багц цаг цуглуулсан оюутанд дээд боловсролын бакалаврын зэрэг олгоно.
- 9.3. Оюутанд олгох бакалаврын зэрэг нь сургалтын төлөвлөгөөнд заасан хичээлийн багцаар тооцогдоно.
- 9.4. Оюутны суралцах хугацаандаа бүрэн судалсан, төгсөлтийн өмнөх комисстой дүнгийн тулгалт хийж баталгаажуулсан хичээлүүд, дүнгийн хамт дипломын хавсралтад бичигдэж, төгсөлтийн програмд бүртгэгдэнэ.
- 9.5. Оюутан хичээлээ сонгон, сургалтаа хэрхэн төлөвлөснөөс хамааран 3.5–6 жилд төгсөх боломжтой. 6 жилээс хэтэрсэн оюутныг төгсөх боломжгүй оюутан хэмээн үзнэ.
- 9.6. Төгсөгч хавсарга мэргэшлээр, эсвэл суралцаж байгаа чиглэлээсээ өөр давхар мэргэжлээр суралцсан тохиолдолд тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний дагуу заавал болон сонгон суралцах хичээлүүдийг амжилттай судалж, мэргэжлийн тэнхимээс холбогдох дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн байна.